

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

1. Ерөнхий агуулга, зохицуулах харилцаа, зарчмын шинжтэй зохицуулалт:

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй бөгөөд тус зүйлд Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан. Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр” нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т Улсын Их Хурал заавал соёрхон батлахаар заасан олон улсын гэрээнд хамаарна.

2. Тухайн харилцааг урьд нь хууль, эрх зүйн бусад актаар зохицуулж ирсэн байдал:

Тус хуулийн төслөөр Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг соёрхон батлахаар зохицуулсан бөгөөд тус харилцааг урьд нь хууль, эрх зүйн актаар зохицуулаагүй болно.

3. Хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан хууль санаачлагчаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ:

Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газарт хүсэлтийг уламжилж, Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн төслийг хамтран боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 20 дугаар хуралдааны тэмдэглэл, 2026 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдааны санал, дүгнэлт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 134 дүгээр захирамжийг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрт Сангийн сайд З.Мэндсайхан 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр гарын үсэг зурсан.

4. Гадаад орны туршлага, бусад судалгаа, шинжилгээний тайлангийн дүгнэлт:

Хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан судалгааны үр дүнд “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд хэлэлцээрийг соёрхон батлуулах нь үр дүнтэй хувилбар гэж дүгнэсэн.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийн талаар

1. Зохицуулахаар тусгасан харилцааны агуулга, зохицуулалтыг хэрхэн ойлгох тухай:

Хуулийн төсөлд Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлахаар тусгасан.

Энэхүү Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд байгуулсан “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр” нь Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2-т Улсын Их Хурал заавал соёрхон батлахаар заасан “гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаархи олон улсын гэрээ”-нд хамаарна.

Уг хуулийн төслийг соёрхон баталснаар хоёр улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн эх үүсвэрийг баталгаажуулж, тус эх үүсвэрээр Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан эрүүл мэндийн чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэх, соёл, урлагийг хүүхэд, залуучууд, бүх нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилготой дараах 7 төслийг хэрэгжүүлэх боломжтой болно. Үүнд:

1. “Хорт хавдрын нейронавигац, стереотактик оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл”,
2. “Гэмтэл согогийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл”,
3. “Монгол Улсад эх, хүүхэд, нярайн эндэгдлийг бууруулах төсөл”,
4. “Улсын нэгдүгээр төв эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”,
5. “Цэргийн төв эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төслийн III шатны төсөл”,
6. “Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн ба хилийн баруун, зүүн бүсийн эрүүл мэндийн байгууллагуудын багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, суурилуулах, хүний нөөцийг чадавхжуулах дараагийн шатны төсөл”,
7. “Дуурь бүжгийн эрдмийн театрын тайз, дуу авианы тоног төхөөрөмжийн шинэчлэл төсөл”.

“Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн танилцуулга болон хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэх төслүүдийн мэдээллийг хавсаргав/.

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Австри Улсын Засгийн газар хоорондын “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн төслийн тухай

1. “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр” байгуулах шаардлага

Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.2 дахь заалтад “гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаархи олон улсын гэрээ”-г Улсын Их Хурал заавал соёрхон батлахаар заасны дагуу Засгийн газрын гадаад зээлийн хэлэлцээрийг Улсын Их Хурлаар соёрхон батлуулдаг хуулийн зохицуулалттай.

Монгол Улсын урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан, эдийн засгийн үр өгөөжтэй, Бүгд Найрамдах Австри Улс (цаашид “БНАУ” гэх)-ын санхүүжилтээр хэрэгжүүлэх боломжтой төслүүдийг тодорхойлж, хоёр тал санал солилцон, санхүүжилтийг баталгаажуулахаар “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-т 2026 оны 06 дугаар сарын 10-ны өдөр гарын үсэг зураад байна.

“Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн хүрээнд нийт 65.0 сая еврогийн эх үүсвэрийг авч ашиглах боломжтой бөгөөд зээлийн эх үүсвэр нь 1 хувийн хүүтэй, 0.9 хувийн баталгааны шимтгэлтэй, 19 жилийн хугацаатай, эхний 4 жилд үндсэн төлбөрөөс чөлөөлөгдөх нөхцөлтэй болно.

Цаашлаад “Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийг УИХ-аар соёрхон батлуулснаар хэлэлцээрийн эх үүсвэрийг заавал авч ашиглах үүрэг хүлээхгүй бөгөөд энэ нь зээлийн гэрээ биш юм. Харин хэлэлцээрийг Улсын Их Хурал соёрхон баталсан тохиолдолд БНАУ-тай хамтран хэрэгжүүлэх төслийн тусгайлсан зээлийн гэрээг байгуулж ажиллах боломжтой болно.

2. Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төслүүдийн талаар

“Санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээр”-ийн хүрээнд төсөл хэрэгжих байршлуудад тоног төхөөрөмж худалдан авах, хүний нөөцийг чадавхжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх бөгөөд энэ хүрээнд дараах төслүүдийг хэрэгжүүлэхээр байна. Үүнд:

№	Төслийн нэр	Төслийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ, үр дүн	Нийт зээл /сая евро/
1	Хорт хавдрын нейронавигац, стереотактик оношилгоо, эмчилгээний төв байгуулах төсөл	<p>Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/273 дугаар тушаалаар баталсан “Монгол Улсад эмчлэх боломжгүй өвчний жагсаалт”-ын “А-1” заалтыг хасах нөхцөлийг бүрдүүлэн, мэдрэлийн мэс заслын нейронавигац, стереотактик оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, нэн шаардлагатай төхөөрөмжүүдийг бүрэн суурилуулах зорилготой бөгөөд дараах зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн:</p> <ul style="list-style-type: none"> • Мэдрэлийн мэс заслын нейронавигац, стереотактик оношилгоо, эмчилгээний орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, нэн шаардлагатай 30 нэр төрлийн тоног төхөөрөмжийг бүрэн суурилуулах; • PET-СТ-ийн өгөгдлийг нейронавигац, стереотактик системтэй интеграцчилж, тархи, нуруу нугасны гүний болон төвөгтэй байрлалтай хавдрын биопси, мэс засал, туяа эмчилгээний аюулгүй байдал, үр дүнг дээшлүүлэх; • Мэдрэлийн мэс заслын эмч, бусад мэргэжилтнийг олон улсын түвшинд бэлтгэх. 	10.0
2	Гэмтэл согогийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, тоног төхөөрөмжийг сайжруулах төсөл	<p>Гэмтэл согог судлалын үндэсний төвийн тусламж, үйлчилгээнд оношилгоо, эмчилгээг сайжруулах орчин үеийн тоног төхөөрөмжийг нэвтрүүлж, тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх бөгөөд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн:</p> <ul style="list-style-type: none"> • Орчин үеийн өндөр нарийвчлалтай тоног төхөөрөмж нэвтрүүлснээр оношилгооны чанар сайжирч, эмчилгээний үр дүн дээшилснээр өвчтөний эдгэрэлт, нөхөн сэргээлтийн хугацаа богиносгох бөгөөд мэс заслын дараах хүндрэлийг 30 хүртэл хувиар бууруулна. • Эрчимт эмчилгээний тоног төхөөрөмжийг шинэчилснээр өвчтөний амь насыг аврах чадвар нэмэгдэнэ. Оношилгоо, хяналтын үр дүн сайжирч, хүнд өвчтөнд үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмж нэмэгдэхийн сацуу нас баралтын түвшин буурна. • Тоног төхөөрөмж ашиглалт, халдвар хяналтын сургалт, Мэс заслын протокол хэрэгжүүлэх дадлага сургалт явуулах. 	7.5
3	Монгол Улсад эх, хүүхэд, нярайн эндэгдлийг бууруулах төсөл	<p>Монгол Улсад ургийн гаж хөгжлийг эрт оношилж, нярайн мэс заслын тусламж, эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний хүртээмж, эх, нярай, хүүхдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулснаар эх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах бөгөөд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн:</p> <ul style="list-style-type: none"> • Эх, эмэгтэйчүүдийн мэс засалд орчин үеийн шинэ технологи нэвтрүүлж, ургийн гаж хөгжлийн оношилгоог шинэ шатанд хүргэх; • Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд шинэ технологийг нэвтрүүлснээр ураг, нярайн мэс заслын тусламжийг сайжруулж, нутагшуулах; • Хүүхдэд эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний хүртээмжийг сайжруулах. 	8.0
4	Улсын нэгдүгээр төв эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах төсөл	<p>Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологи бүхий тоног төхөөрөмжийн баазыг бүрдүүлж, оношилгоо, эмчилгээний чанар, хүртээмжийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах замаар иргэдийн нас баралтыг бууруулж, амьдралын чанарыг дээшлүүлэх бөгөөд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн:</p>	10.0

		<ul style="list-style-type: none"> • Эрхтэн, эд, эс шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд шаардлагатай дэвшилтэт технологи, өндөр хүчин чадалтай тоног төхөөрөмжийг үе шаттайгаар нэвтрүүлэх; • Шилжүүлэн суулгах эмчилгээний тоо, хүртээмжийг нэмэгдүүлж, хүлээгдлийн хугацааг бууруулах; • Эмчилгээний үр дүнг сайжруулж, мэс заслын болон мэс заслыг дараах хүндрэлийн эрсдэлийг бууруулах; • Бөөр, элэг, зүрх, уушги зэрэг амин чухал эрхтний архаг дутагдалтай өвчтөнүүдийн нас баралтыг бууруулж, амьдрах хугацаа, чанарыг нэмэгдүүлэх; • Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг дотооддоо өндөр түвшинд үзүүлэх нөхцөлийг бүрдүүлж, гадаадад эмчлүүлэх урсгалыг бууруулах. 	
5	Цэргийн төв эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэх төслийн гуравдугаар шатны төсөл	<p>Цэргийн төв эмнэлэгт урьд өмнө нь хийгдэх боломжгүй байсан оношилгоо, эмчилгээнүүдийг хийж, ард иргэдийн гадаад орон руу явж эмчлүүлэх урсгалыг багасгаж, эх орондоо харьцангуй хямд өртгөөр эмчлүүлэх боломжийг бүрдүүлэх бөгөөд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн:</p> <ul style="list-style-type: none"> • Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төвийн Хор судлалын лаборатори; • Цус шүүх, цэвэршүүлэх эфферент эмчилгээ; • Бүх төрлийн уян дурангийн оношилгоо, эмчилгээ; • Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх Цусны банк; • Эрхтэн шилжүүлэх мэс засал; • Олныг хамарсан гамшиг, ослын амь тэнссэн үед ашиглагдах хээрийн эмнэлгийн чадамж, чадавхыг дээшлүүлэн орчин үеийн дэвшилтэт техник, технологи бүхий эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх. 	10.0
6	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн ба хилийн баруун, зүүн бүсийн эрүүл мэндийн байгууллагуудын багаж, тоног төхөөрөмжийг шинэчлэх, суурилуулах, хүний нөөцийг чадавхжуулах дараагийн шатны төсөл	<p>Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн оношилгоо, шинжилгээ, эмчилгээний чадавхыг сайжруулснаар ард иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж сайжрах бөгөөд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн:</p> <ul style="list-style-type: none"> • Эмнэлгийн оношилгоо, шинжилгээ, эмчилгээний чадавхыг нэмэгдүүлснээр төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулж, төв эмнэлгүүдийн ачааллыг бууруулах, өвчлөл, нас баралтыг бууруулах нөхцөлийг бүрдүүлэх; • Эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдийг тоног төхөөрөмжийн ашиглалт болон мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх сургалт хийх; • Хилийн бүс нутагт ажиллаж, амьдарч буй алба хаагчид болон хил орчмын оршин суугчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг ойртуулах. 	9.5
7	Дуурь, бүжгийн эрдмийн театрын тайз, дуу авианы тоног төхөөрөмжийн шинэчлэл	<p>Дуурь, бүжгийн эрдмийн театрын барилгын өнөөгийн шинж төрхийг алдагдуулахгүйгээр дотоод хүчитгэл, тоног төхөөрөмжийг шинэчлэн сайжруулах бөгөөд төслийн хүрээнд театрын тайз, гэрлийн тоног төхөөрөмж болон дуу авианы тоног төхөөрөмжийг шинэчилж олон улсын стандартын шаардлагын дагуу үйл ажиллагаа явуулах боломж бүрдэнэ.</p> <p>Театрт жилийн тоглолтын тоог 126 болгон нэмэгдүүлж, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлж, олон улсын чанартай тоглолт, арга хэмжээний тоог нэмэх, дэлхийн нэр хүндтэй уран бүтээлч, уран бүтээлийг өөрийн тайзнаа тоглуулах боломж бүрдэх бөгөөд тус байгууллагын санд байгаа уран бүтээлийн ашиглалт, эргэлт сайжирч, үзэгчдийн соёл, урлагийн хүртээмж нэмэгдэх ач холбогдолтой.</p>	10.0

3. Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцсэн байдал

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-т зааснаар Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байхаар хуульчлагдсан. Эдийн засаг 2027-2029 оны хооронд харгалзан 5.8 хувь, 6.0 хувь, 6.3 хувиар тус тус өсөж, Монгол Улсын 2027 оны төсөв, 2028-2029 оны төсвийн төсөөлөлд тусгагдсан гадаад зээлийн хөрөнгийг авч ашиглах тохиолдолд нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн Засгийн газрын өрийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 2026 онд 43.2 хувь, 2027 онд 46.3 хувьтай, 2028 онд 48.3 хувьтай байхаар тооцоологдсон.

Ингэснээр дунд хугацаанд Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тухай төсвийн тусгай шаардлага болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн хязгаарыг хангахаар байна.

---o0o---